



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 219,558,000.00 (хоёр зуун арван есөн сая таван зуун тавин найман мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Алтангэрэл, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж (улсын дугаар Төрийн тусгай хамгаалалтын газарт хадгалагдаж үлдэнэ), арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005908  
22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 08 дугаар сарын 08 өдрийн  
 1/3 Дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ ҮНИЙГ  
 ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНД БАЛАНСААС  
 БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Лексус 570, арлын дугаар JTJHY00W304108134	2012	219,558,000.00	Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцан захиргаа	20,000,000.00	2
	Нийт дүн		219,558,000.00 (хоёр зуун арван есөн сая таван зуун тавин найман мянган)		20,000,000.00 (хорин сая)	